

Монгол Алтайгаас олдсон эртний нум сум

Ноостын Баярхүү^{1, *}, Хөхийн Бямбажав²

Товч агуулга: Тус өгүүлэлд Монгол Алтайн нурууны төв хэсэг, Баян-Өлгий аймгийн нутгаас олдсон эртний нэгэн зүймэл нум, сумны тухай өгүүлэх ба олдсон газар, хадгалалтын байдал, хэлбэр, ур хийц, дагалдах эд зүйлсийн эрдэм шинжилгээний тодорхойлолт, зарим гэрэл зураг болон гар зураг зэргийг бүрнээр анх удаа нийтлүүлж байна. Мөн Алтайн бүс нутгийн хэмжээнд олж илрүүлэн судлаад буй хадны оршуулгуудаас олдсон ижил төстэй олдворуудтай харьцуулан судлах замаар тухайн олдворын харьцангуй он цагийн талаарх өөрсдийн саналыг дэвшүүлэв.

Түлхүүр үг: Монгол Алтай, хадны оршуулга, зүймэл нум, нум сум, гурван хянгат зэв

Удиртгал

Уг олдворыг Монгол Алтайн нурууны төв хэсэг, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутгаас анх олж илрүүлсэн байна. Тодруулбал, 2012 онд Сагсай сумын нутаг, аймгийн төвийн баруунтай орших Бөхөн ууланд мал хариулж явсан нэгэн казах хүн анх олж үзээд ашиг хонжоо хайн гэртээ авч харьсан байна. Улмаар тухайн үеийн ШУА-ийн харьяа, Баян-Өлгий аймаг дахь НЭЗСТ (Нийгэм эдийн засгийн судалгааны төв)-ийн ажилтан Б.Жаргалсайханд эртний нум олсон ба зарах хүсэлтэй байгаагаа хэлснээр тэд харилцан тохиролцож тодорхой мөнгөн дүнгээр худалдаж авсан байна. Тэрээр худалдаж авсан эртний уг нумыг Улаанбаатар хотноо авч ирж “Тод номын гэрэл” төвийн эрдэм шинжилгээний ажилтан, МУИС-ийн докторант нум урлаач, спортын мастер Х.Бямбажавт үзүүлснээр бидэнд эртний энэ нумыг судлах боломж олдсон юм.

Нумын тухайд Бөхөн уулнаас олсон гэхээс чухам хаанаас, ямар орчноос өөрөөр хэлбэл хадны хөмгөөс, агуйгаас олсон уу гэдэг талаар тодорхой мэдээлэл өгөөгүй ажээ. Хэдий тийм боловч энэ нь угтаа хадны оршуулгад дагалдуулж тавьсан нум болох нь тодорхой бөгөөд энэ удаад зөвхөн уг нум болон дагалдах эд зүйлсийн талаар өгүүлэх ба цаашид уг хадны оршуулгыг илрүүлэн олж бүх талаас нь нарийвчлан судлах шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд манай улсын нутгаас үүнтэй ижилсэх хадны оршуулгууд бараг бүтэн хэвээр өнөөг хүртэл хадгалагдаж байгаад санаатай болон

санамсаргүй байдлаар мэргэжлийн бус хүмүүс олж, улмаар ашиг хонжоо хайн хөндөх, сүйтгэх нь элбэг болж байна. Бөхөн уулнаас олсон гэх энэ нум ч үүний нэг тод жишээ болно.

Бүс нутгийн хадны оршуулгын судалгааны тойм

Монгол орны уулархаг бүс нутгаас хадны оршуулгын дурсгал олноор олддог бөгөөд тэр дундаа Монгол Алтайн нуруугаар энэ төрлийн дурсгал арвин их байгаа нь сүүлийн 30 орчим жилийн хугацаанд бараг тасралтгүй илэрч байгаагаас тодорхой харагдана. Монгол Алтайн нуруунаас олж илрүүлсэн хамгийн анхны хадны оршуулгын мэдээ тэртээ 100 гаруй жилийн өмнө Оросын худалдаачин А.В.Бурдуковын тэмдэглэлд Ховд аймгийн Мянгад сумын Улаан-Үнээт уулын орчимд хадны оршуулга үзсэн тухай тэмдэглэл юм (Бурдуков 1987). Үүнээс хойш Ховд аймгийн хэд хэдэн сумдын нутгаас хадны оршуулга олдсон байна. Тодруулбал, Бага агуй, Бага Баавай, Хар говийн дээд өвөлжөө (Наваан 2018; Эрдэнэбат 2009; Эрдэнэбат, Амартүвшин 2010), Түвшин Буурын агуй, Жаргалант хайрхан, Чонот уул, Булган уул, Улиастайн ам, Хөтөл Өтөг, Эхэн Овоот (Төрбат *et al.* 2008), Урд Улаан Үнээт уул (Баярсайхан *et al.*, 2016), Үзүүр Гялан (Мөнхбаяр *et al.* 2016) зэрэг газруудаас хадны оршуулга илрүүлэн олж судалжээ.

Харин Баян-Өлгий аймгийн нутагт хадны оршуулгын анхны судалгааг 1989 онд хийсэн байна. Тухайн үеийн ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс баруун хэдэн аймгийн археологийн карт зохиох ажлын хүрээнд тус аймагт томилогдон ажилласан Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нар археологийн дурсгалыг бүртгэх явцдаа нутгийн иргэдийн мэдээллийн дагуу гурван

¹ ХБНГУ-ын Майнц дахь Лейбницийн археологийн төв

² МУИС-ийн ШУС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн докторант

* Холбоо барих зохиогч: nbayaraa2001@gmail.com

<https://orcid.org/0000-0001-6144-3014>


газарт хадны оршуулгын дурсгалыг малтан судалжээ (Баяр, Эрдэнэбаатар, 1989). Эдгээр нь Улаанхус сумын Алхамын хавцал, Алтанцөгц сумын Хуурай уул, Буянт сумын Их Мааньт уулын хадны оршуулгууд юм. Тэд хадны оршуулгын талаарх мэдээллийг шалгаж газар дээр нь очиж үзэхэд бүгд урд нь хүний гараар хөндөгдөж сүйдсэн байсан боловч судлаачид бүрэн баримтжуулалт хийж малтан судалжээ. Хожим хадны оршуулга тус бүрээс гарсан эд зүйлсийн үлдэгдэл болон хүний яснаас дээж авч холбогдох он цагийг тогтоожээ. Хуурай уулын хадны оршуулга НТ IV зууны сүүл үе, Их Мааньт НТ VIII зууны дунд үе, Алхамын хавцал XI зууны эхэн үе гэсэн үнэмлэхүй он цагийг лабораторийн шинжилгээгээр тогтоосон байна (Эрдэнэбаатар 1996). Эдгээрээс зөвхөн Алхамын хавцалын хадны оршуулгаас хэдэн хүрэл зэв илэрсэн ба бусдаас нь ямар нэг зэр зэвсгийн холбоотой зүйлс

илрээгүй ажээ. Гэхдээ уг дурсгалууд бүгд нэгэнт хүний гараар хөндөгдсөн байсан тул анх зэр зэвсгийн зүйлс байсан эсэх нь тодорхойгүй юм.

Үүнээс хойш тус аймгийн нутгаас хэд хэдэн газраас хадны оршуулга илэрч олджээ. Эдгээр нь: Нүцгэний гол (Өмирбек *et al.* 2009), Хөх Эрэг, Их Хөшөөт (Эрдэнэбат 2009), Хагт (Амартүвшин, Батдалай, 2020) -ын хадны оршуулгууд юм (Зураг 1). Мөн үүнээс гадна малчин иргэдийн мэдээллээр тус аймгийн Буянт сумын нутагт хадны оршуулга байсаар байгаа тухай мэдээ бий.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Олдворын талаар анх 2012 онд Баян-Өлгий аймаг дахь НЭЗСТ (Нийгэм Эдийн Засгийн Судалгааны Төв)-ийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Золбаяр,



Зураг 1. Монгол Алтайн нуруунаас илрүүлэн судалсан хадны оршуулгууд

Б.Жаргалсайхан нар анхны мэдээллийг судлаачдын сонорт хүргэх зорилгоор эрдэм шинжилгээний тэмдэглэл бичиж нийтлүүлжээ (Золбаяр, Жаргалсайхан 2012).


Олдворуудын тухайд Бөхөн уулнаас олсон гэх бараг бүтэн нум, суран хөвч, арьсан учиг (нум агуулах уут), дагалдах гурван хянгат дуут сум (хугархай) нэг ширхэг, хугархай мөс 3 ширхэг зэрэг эд зүйлс юм. Хэдийгээр өөр нэмэлт мэдээлэл үгүй боловч чухам аль үед холбогдохыг нэхэн тодруулахад эдгээр олдвор чухал хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй. Олдворуудыг тус бүрд нь тодорхойлбол:

Зүймэл нум. Өмнө өгүүлсэнчлэн Бөхөн уулын энэ нумыг анх оршуулгад дагалдуулж тавихдаа хөвчилсөн хэвээр тавьсан бөгөөд он цагийн эрхэнд хэт хатсанаас болж нэг талын эвэр элэг дунд хэсэгтээ наалт нь салж, бага зэрэг хугарсан байна. Улмаар нэг талын гичрийн үзүүрт ус чийг хүрч аажмаар модон гичрийн үзүүр тал буюу хөвчний гогцоо бүхий хэсэг ялзарч муудан үрэгдсэн бололтой.

Харин нумыг анх хөвчилж тавьсан гэж үзсэн нь хөвч шулуун байдалтай хатсан байгаагаас тодорхой мэдэгдэж байна. Нуманд өөр ямар нэг гэмтэл үгүй тул бүтэн талын гичрийн уртын хэмжээгээр үрэгдэж үгүй болсон хэсгийн хэмжээг тооцоолж уг нумын нийт уртыг тодорхойлох бүрэн боломжтой юм. Түүнчлэн үзүүр хэсэг хугарсан талаас нь уг нумын гичир,

элэгний наалт болон үндсэн үүсгэр зэргийг чухам ямар байсныг тодорхойлох бололцоог давхар олгож байна. Үүнд уг нумын гол үүсгэрийг гичир заадаслаагүй, үргэлж модоор төлөв гаргаж хийсэн бололтой гичрийн утг зүйж залгасан байдал мэдэгдэхгүй ба өвөр талд эвэр элэг, ар талд шөрмөс шиллэн наасан нь тодорхой мэдэгдэж байна.

Нумын хийцийн онцлогуудаас дурдвал: Нумын модон үүсгэр нь хоёр талын балчин гичиртэйгээ үргэлж, харин хоёр балчинг бариулын хэсэгт тагнайлдан залгасан байна. Үүсгэр модны ард шөрмөс шүхэрлэн нааж, үхрийн эврээр элэг хадсан, бариул болон гичрийн уулзварт шөрмөс хөндлөн ороож бэхэлсэн, гадуураа ямар нэгэн үйс зэргээр хулдаж бүрээгүй. Ерөнхий хэв нь бараг шулуун хэлбэртэй бөгөөд бариулаас хоёр балчинд шилжих хэсгээр 8 хэмийн өнцөг үүсгэсэн, эвэр элэг төгсөж гичирт шилжих хэсэгт 6 хэмийн өнцөг үүсгэсэн, гичрийн үзүүр хэсгийг мөн 6 хэмээр бага зэрэг махир болгон үйлджээ. Бас нэг онцлог нь нумын бариулын хоёр хажуу талаас хавчиж наасан ясан наалт, бариулын өвөр талд тэвх болгон наасан нэг буюу нийт гурван ширхэг ясан наалттай. Уг нум тэгш хэмт буюу хоёр талын гичир болон балчингууд адил хэмжээтэй байсан нь илт бөгөөд бүтэн талын гичрийн үзүүрээс бариулын төв хэсэг хүртэлх урт 73 см тул сэргээж тооцвол 146 см урттай нум байжээ (Зураг 2).



Зураг 2. Нумын гар зураг ба хөндлөн огтлолын нарийвчилсан хэмжээсүүд

Хөвч. Нумын хөвч нь үрэгдэж, сарниагүй бүтнээр үлдэж хоцорчээ. Бог мал эсвэл гөрөөс мэт амьтны арьсыг нойтноор нарийн зүсэж, мушгин эрчилж хийжээ. Хөвчний нийт урт 116,5 см бөгөөд хадгалалтын нөхцөлөөс шалтгаалж бага зэрэг агшсан байх магадлалтай. Хоёр үзүүрийн хэсэгт амгавч (амгайвч)-ийг хөвчнөөс нь шууд гогцоо зангидаж гаргасан байна (Зураг 3-1).

Нумын арьсан уут буюу учиг. Энэ нь маш энгийн хийцтэй урт нарийн хэлбэртэй уут бөгөөд арьсыг зөөлрүүлж элдэн боловсруулаад үстэй талыг гадагш харуулж хийжээ. Арьсны зарим хэсэгт үлдсэн үсийг харахад хүрэн бараан өнгийн бүдүүн ширхэгтэй нэлээд шигүү бөгөөд ширүүн үстэй, үслэг амьтны арьс ажээ. Энгийн хийцтэй гэж буй нь элдэв хээ угалз, нэмэлт чимэг, тоноглолгүй бөгөөд хадгалагдаж үлдсэн урт нь 60 гаруй см (Зураг 3-2).

Учгийг оёхдоо нарийсгаж зүссэн арьс-ширний захыг хоёр талаас нь нийлүүлж дээр нь нарийн зүссэн арьс тавьж нийлсэн хоёр үзүүрийг хааж давхарлан, тусгайлан бэлдсэн нарийн шөрмөс утсыг 2-4 давхарлан эрчлэн үдэж оёсон байна. Хадгалагдаж үлдсэн хэмжээ нь: 62 см урт, 5 см орчим голчтой нарийн гонзгой хэлбэртэй. Нэг үзүүрт нь зүйж оёсон жижиг хэсэг байгаа нь ёроол бололтой ба яг энэ хэсэгт урж тасдсан тул тодорхой мэдэх боломжгүй болжээ (Зураг 3-2).

Сум. Нийт 4 ширхэг сум дагалдуулж тавьсан байсан бололтой. Үүнд:

1-р сум. Гурван хянгат төмөр зэвтэй, модон мөс ба зэв хоёрын уулзварт 3 нүхтэй ясан бороог суулгаж хийсэн дуут сум бөгөөд өдтэй хэсэг буюу онь тал нь хугарч үгүй болжээ. Онь тал хугарсан боловч зэвтэй тал нь бүтэн үлдсэн төдийгүй маш сайн хадгалалттай байна. Зэв нь зургаан талт хэлбэртэй, гурван хянгат төмөр зэв (Зураг 4-1) бөгөөд урт 3,5 см, өргөн 2,2 см; ясан бороо: урт 2,6 см, өргөн 1,45 см бол зэв болон ясан борооны нийт урт 6,1 см, харин ясан бороо дээрх нүх дунджаар 3,2 мм голчтой ажээ. Сумны нийт урт 64,2 см ба мөс нь хоёр тал руугаа нарийссан, дунд хэсэгтээ арай өргөн хэлбэртэй. Өөрөөр хэлбэл, голч нь хоёр үзүүр хэсэгтээ 8,8 мм бол дунд хэсэгтээ 9,8 мм ажээ.

2-р сум. Мөн адил онь тал нь хугарсан, зэвийн сурвалжийн хугархай мөсний үзүүрт зоолттой хэвээр үлдсэн ба мөсний үзүүр дээр шөрмөсөөр ороож бэхэлж

байсны үлдэгдэлтэй. Онь талдаа ташуу хугарсан нь эрт цагт хэрэглэж байх явцад хугарсныг эвээр нь нааж хэрэглэж байсан боловч хожим наалтаараа дахин салсан нь уг ташуу хэсэг дээрх цавууны үлдэгдлээс мэдэгдэж байна. Мөсний нийт урт 57,5 см ба өмнөхтэй ижил хоёр тал руугаа нарийссан, дунд хэсэгтээ өргөн хэлбэртэй. Голч нь урд үзүүр хэсэгтээ 8,8 мм бол дунд хэсэгтээ 9,3 мм, харин хойд хэсэгтээ 8,3 мм ажээ (зураг 4-2).


3-р сум. Онийн ад хугарсан боловч хөвч сууж байсан ором нь мэдэгдэнэ. Мөсний үзүүр дээрх тойруулсан хэрчлэсэнээс ажиглахад зэвийн сурвалжийн угаар хугарсан бололтой бөгөөд ийн үзвэл зэвтэй байхдаа 60 см-ээс илүүгүй урттай маш богино хэмжээтэй сум байжээ. Мөсний нийт урт 51,2 см ба урдаасаа хойшлох тусам нарийссан хэлбэртэй. Голч нь урд үзүүр хэсэгтээ 9,4 мм бол онь хэсэгтээ 6,3 мм ажээ (зураг 4-3).

4-р сум. Онь тал бүтэн ба үзүүр тал нь хугарсан буюу дундаас хойших хэсэг бололтой. Үзүүр хэсэгтээ энгийн цус бололтой хүрэн толбо ба наалдаж хатсан улаан толбо ихтэй байна. Онь бүтэн бөгөөд 6 мм гүнтэй. Онийг мөсний үзүүрээс шууд сийлж гаргасан ба сэтрэхээс хамгаалж шөрмөсөөр ороож байсан ул мөр үлджээ. Улмаар ониос 2,5 см-ээс эхэлсэн 17 см урттай өдийг мөсний гурван талд тэнцүүлэн наасны хоёр талын өдний ихэнх нь үлдэж хоцорсон байна. Мөсний нийт урт 47,5 см ба урдаасаа хойшлох тусам нарийссан хэлбэртэй. Голч нь урд үзүүр хэсэгтээ 9,8 мм бол онь хэсэгтээ 7,4 мм ажээ (Зураг 4-4).

Олдворуудын харьцуулсан судалгаа

Ер нь эртний зүймэл нум бараг бүтэн хэвээр олдох тохиолдол нэлээд байдаг бөгөөд ихэнхдээ хадны оршуулгад, цөөн тохиолдолд маш хуурай элсэрхэг хөрстэй газарт тавьсан оршуулгад харьцангуй бүтэн хадгалагдаж үлдсэн байдаг. Учир нь ус чийггүй, хуурай бөгөөд сэрүүн, нарны шууд тусгалгүй орчинд хүн малын оршуулга нь хүртэл тэр хэвээр хатаж занданшиж үлдэхээс гадна нум сум болон бусад эд өлгийн зүйлс аажимдаа хатаж бүрэн бүтэн хадгалагдсан байдаг.

Тэгвэл хадны оршуулгаас бүтэн нум илэрсэн нэлээд олон тохиолдол бий бөгөөд зөвхөн Алтайн бүс нутгийн хадны оршуулгаас олж илрүүлсэн бүтэн нум



Зураг 3. Нумын хөвч ба арьсан уут

Хүснэгт 1. Хийц, бүтцийн хувьд ойролцоо нумуудын хэмжээг харьцуулсан байдал

	Хадны оршуулга илэрсэн газрын нэр	Холбогдох он цаг	Нумын урт	Гичирийн урт	Эвэр элэг		
					Урт	Өргөн	Зузаан
1	Урд Улаан Үнээт	НТ 250-301	149 см	36 см, 30 см	42 см, 38 см	5 см	0,9 см
2	Яргайт	НТ 580-675	~ 125 см	~ 25 см	~ 25 см		
3	Жаргалант хайрхан	НТ 590-670	134 см				0,4 см
4	Дугуй Цахир	НТ 895-1021	117 + см	~ 25 см	~ 35 см		
	Дугуй Цахир	НТ 980-1054	63+ см	~ 33 см	~ 30 см		
5	Чонот уул	НТ 1020-1210	133 см	33 см		2,9 см	0,31 см
6	Хагт	НТ 1264-1300	121 см	30 см	30 см	4,5 см	1-2 см
7	Бөхөн уул	-	146 см	33 см	34 см	~ 3,5 см	

өмнө дурдсанчлан Чонот уул, Жаргалант хайрхан, Хагт, Яргайтын зэрэг хадны оршуулгуудаас илэрчээ. Эдгээр хадны оршуулгын нумууд хэлбэр, хийц, хэмжээний хувьд ойролцоо ажээ. Мөн 2015 онд олж илрүүлсэн Урд Улаан Үнээт уулын хадны оршуулгын нум ялимгүй урт хэмжээтэй (Хүснэгт 1) боловч хэлбэрийн хувьд нэлээд төстэй.

Хэдийгээр эдгээр нумууд хэлбэр, хийцийн хувьд ойролцоо боловч холбогдох он цагийн хувьд ялгаатай. Урд Улаан Үнээт уулын хадны оршуулга нь НТ III-IV зууны үед (Баярсайхан *et al.* 2016), Яргайтын оршуулга VI-VII зуун (Баярхүү *et al.* 2024), Жаргалант хайрханы оршуулга нь VII-VIII зууны үед, Чонот уулын оршуулга XI-XIII зууны үед холбогдохыг тус тус тогтоосон байна (Батсүх, Батбаяр 2014).

Түүнчлэн Баянхонгор аймгийн Арцат Дэл, Дугуй Цахир хэмээх газрын хадны оршуулгуудаас зөвхөн нэг талын гичир үгүйгээс бус бараг бүтэн гэж хэлж болох нэг нум, мөн дундуураа хугарч тал хэсэг нь үлдсэн бас нэг нумыг илрүүлжээ (Эрдэнэбат, Амартүвшин, 2010). Арцат Дэлийн хадны оршуулгаас олдсон нум болон бусад олдвор эд өлгийн зүйлсэд хийсэн C14-ийн шинжилгээгээр X зууны дунд үед холбогдох бол харин Дугуй Цахирын оршуулга IX-XI зууны үед холбогдохыг тогтоожээ (Эрдэнэбат, Амартүвшин 2010). Дугуй Цахирын 1-р нумын өрөөсөн гичир үгүй боловч бүтэн буй гичрийн уртаар тооцон нэмж бодвол 140 см гаруй урттай нум байсан бололтой ба энэ нь Бөхөн уулын нумтай нэлээд ойролцоо урттай болох ба түүнээс гадна уг нумын гичрийг залгаасгүйгээр модон үүсгэрээс нь үргэлжлүүлж хийснээрээ Бөхөн уулын нумтай ижилсэж байна.

Дагалдах сумны тухайд дээр дурдсанчлан зэвтэй дуут сум нэг, хугархай мөс 3 бий бөгөөд хэлбэрийг ажиглахад бүгд хоёр тал руугаа нарийссан хэлбэртэй,

төв хэсгээрээ арай өргөн голчтой байна. Сумны ийм хэлбэртэйг нь “Могой” сум гэж нэрлэх нь бий. Бидэнд буй 4 сум бүгд ийм хэлбэртэй сум бөгөөд хоёр үзүүр талдаа 6,3-8,8 мм голчтой бол дунд хэсэгтээ 9,3-9,8 мм голчтой ажээ. Ер нь хадны оршуулгаас нумтай хамт түгээмэл илэрдэг олдвор бол саадагтай болон саадаггүй сум юм. Жишээлбэл, Жаргалант хайрханы оршуулгаас нийт 23 ширхэг харвуулын сум илэрсний ихэнх мөс нь бараг бүтэн зөвхөн төмөр зэвүүд нь салсан байдалтай олджээ. Эдгээр сумны мөсийг гурав ба дөрвөөр өдөлсөн байжээ (Батсүх, Батбаяр 2014).

Үүнээс гадна, зөвхөн хадны оршуулга төдийгүй говь, цөлийн бүсийн хуурай, нам дор газрын хөрсөнд үйлдсэн булшинд оршуулга ба дагалдуулсан эд зүйлс нь бүтэн хэвээр хадгалагдан үлддэг байна. Тухайлбал, нэгэн сонирхолтой баримт буй нь 1958 оны өвөл Төвөдийн өндөрлөгийн зүүн хойд хэсгийн их нууруудын хотгорт Хөхнуурын Цайдамын хөндийд орших Голмод хотын ойролцоох Номхон хэмээх тариалангийн талбайгаас монгол баатар эрийн занданшиж хатсан бүтэн шарил, иж бүрэн зэр зэвсэг, өмсгөл хувцастайгаа огт хөндөгдөөгүй байсныг олж илрүүлсэн байна. Уг оршуулгыг хуягласан бүрэн өмсгөл хувцас, зэр зэвсэг (нум сум) –тэй нь эсгийнд ороож гэрийн ханан дээр тавьсан байжээ (Баатар, Эрдэнэбат 2011). Гэхдээ энэ оршуулга нь хадны хөмөг, хөндий бус газрын хөрсөнд байсан боловч тухайн газар нь хуурай, элсэрхэг хөрстэй тул занданшиж бүрэн бүтнээрээ хадгалагдан үлдсэн байна.

Уг оршуулгад дагалдуулсан нумын гэрэл зургийг ажиглахад нэлээд урт хэмжээтэй бөгөөд хөвчилсөн хэвээр удаан байснаас нэг талын элэгний зах буюу бариулын хажуугаар бага зэрэг эвдэрч хугарснаас хөвч суларсан байдалтай байх ба өөр гэмтэл үгүй бололтой. Уг дурсгалыг дагалдуулсан эд зүйлс, цаасан мөнгө



Зураг 5. Нэхэн сэргээж хийсэн нум, хөвчилсөн ба эвшээлгэсэн байдлын гар зураг

зэрэгт тулгуурлан он цагийн хувьд эргэлзээгүйгээр Юань улсын үед холбогдохыг тогтоожээ (Баатар, Эрдэнэбат 2011).

Сүүлийн жилүүдэд энэ мэт бараг бүтэн хадгалалттай нум сум, хадны оршуулгаас болон нам дор газрын булшнаас илэрч олдсоор байна.

Хэлэлцүүлэг

Монгол нутгаас археологийн малтлагаар бүтэн нум илрүүлсэн тохиолдол хэд хэд бий боловч бүгд хадны оршуулгаас илэрсэн бөгөөд газрын хөрсөнд нүх ухаж үйлдсэн булшнаас нумын зөвхөн зарим хэсгүүд болох эвэр, ясан наалтууд гардаг ба харин модон үүсгэр гарах тохиолдол тун ховор. Булшнаас модон үүсгэр илэрсэн тохиолдол одоогоор ердөө ганц байгаа нь Түрүү төмөр зэвсгийн үеийн Пазырык булшнаас илэрсэн зүймэл модон нум болно (Эрдэнэ-Очир, Батсүх 2016). Уг нум нь Алтайн нурууны өндөрлөг, сэрүүн бүс нутагт үйлдсэн цэвдэгтэй булшинд байсан тул хөлдөж улмаар хадгалагдан үлдэж чадсан байна. Нумын бүтцийн хувьд зүймэл нум мөн боловч эвэр, эсвэл ясан наалт илрээгүй ба зөвхөн модоор зүйж хийгээд нэмэлт модон наалт наасан байжээ. Нумын ерөнхий хэлбэрийг харахад тэгш бус хэмтэй байсан нь илт мэдэгддэг байна (Эрдэнэ-Очир, Батсүх 2016: 109, Зур. 5).

Харин нумын ясан наалтууд хүрэл зэвсгийн үеийн сүүл үеийн дөрвөлжин булш, Хүннүгийн жирийн иргэдийн булш, дундад эртний үеийн булшнууд болон Дундад зууны зэрэг үе үеийн булшнаас илэрдэг.

Ялангуяа Хүннүгийн үеийн булшнаас түгээмэл илэрдэг олдворын нэг бол нумын ясан наалт болохыг судлаачид дурддаг (Төрбат *et al.* 2003) бөгөөд булшнаас илэрдэг ясан наалтуудын тоо ширхэгт үндэслэн нумын хэмжээ, хэлбэр хийцийн талаар нэхэн

сэргээлт судалгааг ахмад археологич З.Батсайхан хийсэн байдаг (Батсайхан 2022).

Ойрын хэдэн жилд олдсон нумын ясан наалтын тухай жишээг дурдвал, Ховд аймгийн Булган сумын Авын хөх уулын хүннүгийн үеийн булшнаас долоон ширхэг ясан наалт илэрсэн нь гичрийн хоёр хос буюу дөрөв, бариулын гурван ширхэг ясан наалт огт хөдөлсөн шинж тэмдэггүй үндсэн байрлалдаа хэвээр илэрсэн ба он цагийн уртад модон үүсгэр нь үгүй болж ясан наалтууд тухайн байрлалдаа үлдсэн байжээ (Төрбат *et al.* 2015). Мөн Тамирын Улаан хошууны зарим булшнаас нумын ясан наалт илэрсэн хэд хэдэн тохиолдол (Баярхүү 2021; Төрбат *et al.* 2018), Эгийн голын Баруун Бэлсэгт Хүннүгийн үеийн нэг булшнаас нумын ясан наалтууд анхны байрлалдаа илэрчээ (Эрэгзэн 2018). Энэ мэт Хүннүгийн үеийн булшнаас нумын модон үүсгэр нь үргэгдсэн боловч, ясан наалтууд уг байрлалдаа хэвээр хадгалагдан үлдэх тохиолдол шинээр бүртгэгдсээр байна.

Тэгвэл Бөхөн уулын нумын хугарсан гичир ба элэг орчмыг ажиглахад ерөнхий бүтэц, хийцийг мэдэх боломжтой. Өөрөөр хэлбэл, модон үүсгэр, шөрмөсөн ар, эвэр элэг зэргийн хоорондын зохих харьцааг нарийвчлан судлах бололцоог олгож буй тул тус өгүүллийн зохиогчдын нэг, нум урлаач Х.Бямбажав нэхэн сэргээж хийж үзэхэд хэлбэрийн хувьд энгийн, одоогийн дундаж нумаас илүү хүчтэй нум болсон ажээ (Зураг 5).

Үүнээс үзэхэд уг нум нь Хүннүгийн үеийн нэхэн сэргээсэн нумуудын гадаад хэлбэр төрхтэй ижил, зүймэл нум болох нь тодорхой ба Хүннүгийн үеийн нумаас ялгаатай нь эвэр элэгтэй.

Хийцийн хувьд эрт цагийн нумын өөр хоорондоо ижилсэх нэг зүйл бол орчин цагийн нум шиг гичир дээр нэмэлтээр байрлуулсан хайгуул, товх байдаггүй онцлогтой. Энэ нь археологийн судалгаагаар

батлагдсаар байна. Одоогоор лавтай Түрүү төмөр зэвсгийн Пазырыкийн үе, Хүннүгийн үе, дундад эртний үе болон Их Монгол Улсын үе хүртэлх олон зуун жилийн хугацаанд хэрэглэгдэж байсан нумуудын гичир дээр ямар нэг нэмэлт зүйл буюу хайгуул, товх гэж байгаагүй ажээ.

Харин бидний сайн мэдэх, орчин цагийн наадам (спорт)-ын зориулалттай эвэр элэгтэй, шөрмөсөн артай зүймэл нумаас илт өөр юм. Тодруулбал, харьцангуй урт гичиртэй ба нэмэлт хайгуул, товх гэж үгүй нь нумын эртний хэв шинж төдийгүй орчин цагийн нумаас хэлбэр болоод хийцээрээ эрс ялгарах үндсэн шинж болдог.

Орчин цагт нумын хөвчийг шууд оньд тогтоодоггүй ба хөвчний үзүүрт нэмэлт материалаар битүү гогцоо залгаж “амгайвч” гэж нэрлэдэг. Амгайвч (*орчин цагт амгавч гэх ч бий*) -ийг ихэвчлэн морь, тэмээ зэрэг малын ширээр хийх ба орчин цагт нийлэг материалаар хийх нь түгээмэл болсон. Улмаар амгайвчийг хөвчний үзүүрт холбож сулрахгүйгээр чанга уяад битүү талыг гичрийн үзүүрээс гогддог. Уг амгавч болон хөвчний үзүүрийг холбож зангидсан зангилаа нь хайгуул (эмээл) -ын дундуур товх дээр бууж байхаар тааруулдаг (Зураг 6). Гэхдээ яг ийм хайгуул ба товх нь нумын хөгжлийн явцад харьцангуй хожуу үүссэн ажээ.

Одоогоор мэдэгдэж буй хамгийн эртний товхтой гэж хэлж болох нум бол Цагаан хадны оршуулгаас илэрсэн нум болно (Nomguunsüren *et al.* 2012). Уг нум XIV зууны үед холбогдох хадны оршуулгаас илэрсэн

маш гоёмсог хийцтэй, бараг бүтэн нум бөгөөд анх хөвчилж тавьсан тэр хэвээр олджээ (Зураг 7).

Энэ нум хийцийн хувьд өвөрмөц, нимгэн хавтгай балчинтай бөгөөд мөн хэд хэдэн өнгийн хоршил бүхий гоёмсог чимэглэлтэй, хоёр гичрээс бусад хэсгийг үйсээр бүрсэн ажээ. Хэдийгээр өмнөх цаг үеийн нумуудын хэлбэр хийцтэй дөхүү боловч зарим нэг шинжээрээ эрс өөр болох нь харагдана. Юуны өмнө хөвчийг нэлээд том (орчин цагийн авгавч мэт) гогцоо гаргаж гичрээс гогдсон ба уг гогцооны зангилаа буух хэсэгт шир наасан байна (Зураг 7). Хэдийгээр орчин цагийн өндөр эвэр товхтой ижилгүй, хөвчний зангилаа буух хэсгийг зөөллөж буй (харилтын хүчийг сулруулах) үндсэн үүрэгтэй харагдаж буй боловч дан ганц зөөлөвчийн үүрэг гүйцэтгэхээс гадна чиглүүлэх чухал үүрэгтэй байдаг. Ялангуяа орчин цагт спортын төрөл болон хөгжсөн үндэсний сур харваанд хайгуул, товхгүй нумаар сум алдахгүй (100%) харвах нь нэлээд төвөгтэй болохыг харваачид дуу нэгтэйгээр хүлээн зөвшөөрдөг. Үүнээс үзэхэд нумын хөгжлийн олон зуун жилийн түүхэн хугацаанд хайгуул товх гэх зүйлгүй байсан нум хожим дундаж зууны үеэс эхлэн товхтой болох эхлэл тавигдаж байсан бололтой. Учир нь Цагаан хадны уг нум товхтой байхын чухлыг ойлгож хэрэглэж эхэлж байсан үеийн бодит баримтын нэг байхыг үгүйсгэх аргагүй.

Дараагийн нэг баримт бол хөвчний уяа зангилаа юм. Монголчууд эртнээс нүүдэллэн аж төрж ирсэн бөгөөд нүүдлийн хэв маягт зохицсон амьдралын хэв маяг, түүнээс уламжлагдсан өв соёл, зан заншил арвин их



Зураг 6. Хайгуул, товх, эвэр элэгтэй орчин цагийн нум



Зураг 7. Цагаан хадны оршуулгаас илэрсэн нум (© Nomguunsüren et al. 2012)

бий. Ялангуяа уяа зангилаа гэдэг бол нүүдэлчин ахуй амьдралтай салшгүй холбоотой тул ямар эд зүйлийг яаж уях, зангидах талаар маш олон арга ухаан сэдэж түүнийгээ хэрэглэн түгээж, өвлүүлэн уламжлуулах, бас хөгжлийнх нь явцад нэмэн дэлгэрүүлж, шинэчлэн өөрчилсөөр өнөөг хүрсэнтэй хэн ч маргахгүй.

Тэгвэл өнөөг хүртэл хадны оршуулгаас илэрч олдод буй бүтэн ба бүтэн бус нумуудын хөвчийг тогтоосон байдлыг ажиглахад үндсэн хоёр арга байдаг бололтой.

1. Хөвчний нэг үзүүрийг битүүлж уяад гичрээс гогодох, нөгөө үзүүрийг гичирт шууд ороож уях,

2. Хөвчний хоёр үзүүрийг адил битүү гогцоо гаргаж уяад шууд гичрээс гогодох.

Жишээлбэл, Жаргалант хайрханы хадны оршуулгаас илрүүлсэн нумын хөвчний нэг үзүүрийг битүү гогцоо гаргасан бол нөгөө талыг гичрийн үзүүр дээр хэд хэд ороож уясан байсны үлдэгдэл тэр хэвээр олджээ. Энэ нь уг нумын хөвчийг буулгахдаа зөвхөн нэг талаас нь буюу битүү гогцоотой талыг гичрээс мултлах замаар хөвчийг буулгадаг ба нөгөө тал нь байнгын уяатай байжээ. Мөн Урд Улаан Үнээт уулын хадны оршуулгаас илэрсэн нум нь ассиметрик буюу тэгш бус хэмтэй байсан ба морин дээр харвахад тохирсон доод балчин богино, дээд балчин урт нум байжээ. Уг нумын хөвчний дээд үзүүр битүү гогцоотой, харин доод үзүүрийг нумын доод гичирт ороож бэхлэгдсэн байжээ. Энэ нь мөн л дээд гогцоог мултлах замаар хөвчийг буулгадаг байсны баримт болно.

Харин үүний эсрэгээр хоёр үзүүрийг гогцоо гаргаж уясан тохиолдол ч бий ажээ. Бөхөн уулын нумын хөвчний хоёр үзүүрийг бүтүүлж уяад гичрээс шууд гогоддог байжээ. Мөн хэдийгээр арай хожуу үед холбогдох боловч Цагаан хадны нумын хөвчний хоёр үзүүрийг мөн бүтүүлж уяад гичрээс шууд гогоддог

байсан нь үүнтэй ижил байна. Дашрамд дурдахад, Бөхөн уулын нумын хөвчний битүү гогцооны зангидсан арга нь нэлээд сонирхолтой (Зураг 3). Энэ уяа (зангилаа)-ны онцлог нь огт харьж буцдаггүй уяа буюу “занги уяа” мөн тул нумын хөвчинд маш сайн тохирохыг олж мэдсэнээр ийнхүү уяж хөвчинд хэрэглэж байсны хөдөлшгүй баримт болно. Тийм ч учраас бид орчин цагийн нумын хөвчийг үүнтэй ижил дуурайлган уяж туршиж үзэхэд харьж буцахгүй, сулардаггүй “занги уяа” болох нь батлагдсан болно.

Дүгнэлт

Бөхөн уулаас олдсон уг нумын хийц, хэлбэр, хэмжээ зэргийг Монгол нутагт олж илрүүлээд буй бусад нумтай харьцуулж үзэхэд хэмжээний хувьд дундаж буюу эрт дундад үеийн нумтай үндсэн хийцээрээ ижил байна. Ялангуяа Жаргалант хайрхан ба Чонот уулын хадны оршуулгаас илэрсэн нумтай нэлээд төстэй. Хэдийгээр энэ хоёр оршуулга 300 гаруй жилийн зөрүүтэй үйлдэгдсэн боловч нумын ур хийцийн хувьд нэгэнт сонгодог хэм хэмжээ, хэлбэр хийцээ олсон тул хэдэн зуунаар дамнасан, үндсэндээ ижил хийцийн тогтсон уламжлалтай байсан бололтой. Ер нь энэ хоёр оршуулга өөр хоорондоо болон Жаргалант хайрханы хадны оршуулга ба Бөхөн уулын хадны оршуулга хоёр нь хоорондоо 200 км гаруй зайтай. Өөрөөр хэлбэл энэ нь нэг бүс нутагт хамаарах тул их, бага ямар нэг хэмжээгээр уламжлал, харилцаа холбоотой байсны илрэл гэж үзэж болно.

Харвуулын сумны тухайд мөсний хэлбэр, хийц, өд, төмөр зэвийн хэлбэр хийц зэрэг нь маш нийтлэг, ер нь дундад эртний үеийн төмөр зэвийн хамгийн түгээмэл хэлбэр тул харьцангуй он цагийг нарийвчлан

¹ Занги III. - Хөвөрхий биш уяа, занги уяа (Цэвэл, 1966а).

тогтооход бэрхшээлтэй. Тухайлбал, Оросын Уулын Алтайд малтан судалсан булшнаас илрүүлсэн зэр зэвсгийн зүйл, түүний дотор төмөр зэвийн судалгааг тусгайлан хийсэн судлаачдын бүтээлд хэлбэр төрх, он цагаар нь хэд хэдэн зүйлд хувааж ангилсан нь бий. Гэхдээ энэ нь ихэвчлэн тухайн булшнаас түгээмэл илэрдэг бусад олдворуудтай харьцуулах замаар төмөр зэвийн он цагийн ялгааг тогтоодог бол бидний энэ тохиолдолд дагалдах өөр бусад олдвор үгүй байна.

Хэдийгээр лабораторийн нарийвчилсан шинжилгээ хийж холбогдох он цагийг баттай тогтоогоогүй боловч ижил төстэй олдворуудтай харьцуулж үзэхэд Бөхөн уулын эдгээр олдворууд нь урьдчилсан байдлаар өргөн хүрээнд Монголын эрт дундад үе буюу НТ VII–IX зууны үед холбогдох боломжтой гэж үзэж байна.

Талархал

Тус нумын талаар анхны мэдээллийг нийтэлж судлаачдын сонорт хүргэсэн доктор Г.Золбаяр, Б.Жаргалсайхан нарт талархал дэвшүүлье. Мөн магадгүй үгүй болох эрсдэлтэй байсан уг олдворуудыг бидэнд нүдээр үзэж судлах бололцоог олгосон Б.Жаргалсайханд дахин талархал илэрхийлье.

Abstract

An ancient composite bow and arrows found in the Mongolian Altai Mountains

Noost Bayarkhuu and Khukh Byambajav

The publication presents a composite bow and arrows discovered in 2012 in the Mongolian Altai Mountains, specifically on Bukhun Mountain. The artefacts were found by a Kazakh herdsman and sold to B. Jargalsaikhan, a resident of Bayan-Ulgii. The seller did not disclose the exact location of the find. The artefacts likely came from a rock grave site. Thus, the original buried site remains unknown, but future research will focus on locating and studying the site more comprehensively.

Rock graves are a common form of burial among nomads in the Altai Mountains, and over ten have been found in the last five years. Currently, there is no radiocarbon (C14) date for the artefacts. Still, detailed descriptions and comparisons with composite bows from nearby sites, such as Jargalant Khairkhan and Chonot rock graves, show similarities in shape, dimensions, and style, suggesting that the optimal design for composite bows was likely established by the 7th century. Preliminarily, we assume the composite bow from Bukhun Mountain dates to the early medieval period of Mongolian history,

possibly the 7th to 9th century AD.

Keywords: Mongolian Altai, rock grave, composite bow, bow and arrow, triangular arrowhead

Ном зүй

Nomguunsüren, G., Ahrens, B., & Piezonka, H. (2012). Das Höhlengrab von Cagaan Chad, Bogd sum, Övörchangaј aјmag. In *Steppenkrieger Reiternomaden des 7. - 14. Jahrhunderts aus der Mongolei* (p. 416).

Амартүвшин, Ч., Батдалай, Б. (2020). Хагтын хадны оршуулга. Нүүдэлчдийн Өв Судлал, XXI–II(11), 110–127. УБ.

Баатар, Ш., Эрдэнэбат, У. (2011). Хөхнуурын Цайдмаас олдсон монгол баатрын занданшсан шарил. *Studia Archaeologica*, XXX(11), 205–221. УБ.

Батсайхан, З. (2022). Хүннүгийн түүх, археологийн судлал. Бүтээл туурвилын эмхэтгэл, I боть (Д. Заяабаатар (Ed.)). УБ.

Батсүх, Д., Батбаяр, Т. (2014). Жаргалант хайрханы хадны оршуулга. In Ц. Төрбат, У. Эрдэнэбат (Eds.), *Талын морьтон дайчдын өв соёл* (pp. 206–241). УБ.

Баяр, Д., Эрдэнэбаатар, Д. (1989). 1989 онд Баян-Өлгий аймгийн нутагт явуулсан эртний судлалын хайгуулын ажлын тайлан. УБ.

Баярсайхан, Ж., Түвшинжаргал, Т., Баяндэлгэр, Ч. (2016). Ховд аймгийн Мянгад сумын Урд Улаан Үнээт ууланд хийсэн хадны оршуулгын малтлага судалгаа. *Монголын Археологи-2015*, 86–88. УБ.

Баярхүү, Н. (2021). Тамирын Улаан хошууны 2017 оны малтлагаар илрүүлсэн зэр зэвсэг. In Ц. Төрбат, Э. Крюбезы (Eds.), *Тамирын Улаан хошууны Хүннүгийн соёл (2017 оны малтлага судалгааны үр дүн)* (pp. 133–136). УБ.

Баярхүү, Н., Цэлхагарав, Ц., Батсүх, Д., Ян, Б., Төрбат, Ц. (2024). Түрэгийн түрүү үеийн Яргайтын хадны оршуулга. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, 13(1), 57–64.

Бурдуков, А. В. (1987). Хуучин ба шинэ Монголд (Дуртгалууд). Орос хэлнээс орчуулсан Э. Базаржав. УБ.

Золбаяр, Г., Жаргалсайхан, Б. (2012). Шинээр олдсон нэгэн нум сумны тухайд. Эрдэм шинжилгээний эмхэтгэл. ШУА-ийн Харъяа Баян-Өлгий Аймаг дахь Нийгэм эдийн засгийн судалгааны төв, УБ.:145–147.

Мөнхбаяр, Ч., Пүрэвдорж, Г., Бямбасүрэн, Х., Сүхбаатар, Б. (2016). Үзүүр гялангийн түрэг хадны оршуулгын малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээс. Мөнххайрхан, Булган Гол-Их Онгогийн БЦГ-2016 Хурлын эмхэтгэл, УБ.:164–187.

Наваан, Д. (2018). Ховд аймагт явуулсан археологийн судалгаа. Бүтээл туурвилын эмхэтгэл, III боть (Д. Заяабаатар, У. Эрдэнэбат, Ч. Амарбилиг, Д. Содномжамц (Eds.)). МУИС., УБ.

Өмирбек, Б., Золбаяр, Г., Ансаган, А. (2009). Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэр дахь түүх соёлын дурсгалууд. УБ.

Төрбат, Ц., Амартүвшин, Ч., Эрдэнэбат, У. (2003). Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд. УБ.

Төрбат, Ц., Батсүх, Д., Батбаяр, Т., Баярхүү, Н., Идэрхангай, Т. (2008). Монгол Алтайгаас илэрсэн хадны оршуулгууд. *Studia Archaeologica*, (VI) XXVI(14), 274–292. УБ.

Төрбат, Ц., Батсүх, Д., Бемманн, Я. (2015). Монгол Алтайн өвөр бэлийн Авын Хөх уулын Хүннүгийн булш. *Studia Archaeologica*, XXXV(20), УБ.: 295–323.

Төрбат, Ц., Баярхүү, Н., Эрдэнэ, Б., Батбаяр, Т., Энхбаяр, Г., Гантогтох, Г., Дюшен, С., Николаева, Д., Жирард, Б., Севин-Аллуэ, К. (2018). ‘Тамирын голын Хүннүгийн соёл’ тусгай захиалгат төсөл ба Монгол-Францын хамтарсан ‘Тамир’ төслийн 2017 оны археологийн хээрийн судалгааны ажлын тухай товч. Монголын Археологи-2017. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл., УБ.: 10–15.

Цэвэл, Я. (1966a). Занги III. - Хөвөрхий биш уяа, занги уяа. In Монгол хэлний товч тайлбар толь (p. 266). УБ.

Цэвэл, Я. (1966b). Нумны амгайвч - нумны хөвч торгох торомж. In Монгол хэлний товч тайлбар толь (p. 388). УБ.

Эрдэнэ-Очир, Н., Батсүх, Д. (2016). Монгол Алтайн Пазырыкийн соёлт эртний нүүдэлчдийн зэр зэвсэг. In Ц. Төрбат, Д. Цэвээндорж (Eds.), Монгол Алтайн мөнх цэвдгийн булш, Монголын Пазырыкийн соёл (pp. 105–115). УБ.

Эрдэнэбаатар, Д. (1996). Монгол Алтайн хадны оршуулга. *Studia Archaeologica*, XVI(9), УБ.: 113–121.

Эрдэнэбат, У. (2009). Дундад зууны нүүдэлчдийн оршуулгын дурсгалын өвөрмөц хэлбэр. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, 5(1(344)), УБ.: 54–80.

Эрдэнэбат, У., Амартүвшин, Ч. (2010). Дугуй Цахирын хадны оршуулга (X-XII зуун). УБ.

Эрэгзэн, Г. (2018). Баруун бэлсэгийн хүннү булшнаас олдсон нумын ясан наалт ба хүннү нумын хийцийн асуудалд. *Studia Archaeologica*, XXXVII(8), УБ.: 112–119.

Received: Jan 28, 2025; Revised: March 17, 2025; Accepted: June 5, 2025

